




ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРААР ҮЙЛЧЛҮҮЛЖ БУЙ ИРГЭДЭЭС 2026 ОНЫ ХАГАС ЖИЛД АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

2026 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30 өдрийн хооронд Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраас үйлчилгээ авсан даатгуулагч нараас түүврийн аргаар нийт 203 иргэнээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/184 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар сэтгэл ханалжийн судалгаа авах журмын” дагуу батлагдсан асуумжийн дагуу судалгаа авсан.

СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Асуумж1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 203 иргэдийн насны хувьд авч үзвэл 25 хүртэлх насны 29 иргэн, 25-34 насны 42 иргэн, 35-44 насны 52 иргэн, 45-54 насны 45 иргэн, 55-с дээш насны 35 иргэн тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

Асуумж2:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:



хүйсийн ангилал

■ Эрэгтэй ■ Эмэгтэй




Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс хагас жилийн байдлаар сэтгэл ханамжийн судалгаанд 203 иргэн хамрагдсанаас эмэгтэй 130, иргэн буюу 64.1% нь эрэгтэй 73 иргэн буюу 36.9% гэсэн тоон үзүүлэлт гарч байна.

Асуумж3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн боловсролын байдал:

Боловсрол


■ Дээд ■ Бүрэн дунд ■ Бага ■ Боловсролгүй





Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт иргэдийн боловсролын байдлыг үнэлэхэд боловсролгүй иргэн буюу 0%, бага боловсролтой 2%, бүрэн дунд боловсролтой 32%, дээд боловсролтой 66%-ийг тус бүр эзэлж байна.

Асуумж4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн авч буй үйлчилгээний төрөл:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ авсан төрлийг үнэлэхэд бусад үйлчилгээг 12 иргэн буюу 6.8%, ажилгүйдлийн тэтгэмж 13 иргэн буюу 6.8%, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 13 иргэн буюу 6.8%, сайн дурын даатгал 61 иргэн буюу 30.1%, тэтгэмжтэй холбоотой 17 иргэн буюу 8.8% тэтгэвэртэй холбоотой 87 иргэн буюу 21.4%, тус тус үйлчилгээ авсан байна.


Асуумж5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын албан хаагчаас мэдээллээ бүрэн авсан байдал:





Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт иргэдийн “Хангалттай” гэсэн үнэлгээг 89.3% “Дунд зэрэг” үнэлгээг 7.8%, “Хангалтгүй” үнэлгээг 2,9% тус тус үнэлсэн байна.

Асуумж6:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчтай хэдэн удаа уулзсан талаарх үнэлгээ?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ авахдаа албан хаагчтай 1 удаа уулзсан 52.6%, 2 удаа уулзсан 31.1%, 3 удаа уулзсан 11%, 4 удаа уулзсан 3.3%, 5 удаа уулзсан 2% тус бүр үнэлсэн байна.

Асуумж7: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчтай 3-аас дээш удаа уулзсан шалтгаан?





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Би өөрөө бичиг баримтаа дутуу бүрдүүлсэн” шалтгаанаар 73%, байцаагч ажлын байрандаа байгаагүй шалтгаанаар 8.3%, ачаалал ихтэй байсан шалтгаанаар 16.7%, байцаагч хангалтгүй мэдээлэл хүргэсэн шалтгаанаар 2% тус бүр байна.

Асуумж8: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчдын харилцааны соёлын үнэлгээ?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас албан хаагчийн харилцааны соёлын үнэлгээ авахад “Хангалттай сайн” үнэлгээг 91.1%, “Сайжруулах шаардлагатай” үнэлгээ 5.9% “Хангалтгүй” үнэлгээ 3% тус бүр үнэлсэн байна.


Асуумж9: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын орчин, тав тухтай байдлыг үнэлсэн үнэлгээ:






Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас байгууллагын орчин, тав тухтай байдлын үнэлгээ авахад “Хангалттай” гэж 71.3%, “Сайжруулах шаардлагатай” 22.8%, “Хангалтгүй” гэж 5.9%, тус бүр үнэлсэн байна.

Асуумж10: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын орчин, тав тухтай байдлын юуг сайжруулах шаардлагатай гэж үзэж байгааг үнэлсэн үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдээс орчин, тав тухтай байдлыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн бэ гэсэн асуулгад үйлчилгээний тавцан зохимжгүй байгааг өөрчлөх гэсэн 35.3%, Байцаагч ажилтнаа нэмэхгүй бол маш их оочиртой ачаалалтай байна гэж 29.4% нь үнэлсэн байна.

Асуумж11: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын сурталчилгаа, мэдээллийг авдаг төрөл:






Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдээс нийгмийн даатгалын талаарх сурталчилгаа, мэдээллийг хаанаас авдаг талаарх судалгаа авахад вэб хуудаснаас 14.7%, лавлах утаснаас 2%, байгууллага дээр биеэр ирж 23.5%, нийгмийн сүлжээгээр 42.2%, огт авдаггүй 2%, тараах материал, танилцуулгаас 2%, телевизээс 8.8% тус бүр мэдээллээ авдаг байна.

Асуумж12: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг ашигладаг байдлын үнэлгээ:



Дүгнэлт: Нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг ашигладаг талаарх судалгаа авахад 36.6% нь татаж авч чадаагүй, 51.5% нь тийм, 36.6% нь үгүй гэж тус, тус хариулсан байна.

Асуумж13: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын www.ndaatgal.mn вэб сайтын талаар мэдээлэл авч байсан байдлын үнэлгээ:





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдээс нийгмийн даатгалын www.ndaatgal.mn вэб сайтын талаар мэдээлэл авч байсан талаарх судалгаа авахад 35.6% нь мэдэхгүй, 50.5% нь тийм, 13.9% нь хааяа гэж тус бүр үнэлсэн байна.

СУДАЛГАА НЭГТГЭСЭН:

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АХЛАХ БАЙЦААГЧ:Н.БАТ-ЭРДЭНЭ